



НИЙСЛЭЛИЙН
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 04 сарын 12 өдөр

Дугаар А/17

Улаанбаатар хот

Улаанбаатар хотын аварга шалгаруулах
спорт авиралтын тэмцээнийг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын аварга шалгаруулах спорт авиралтын тэмцээнийг Монгол Уулчдын үндэсний холбоотой хамтран 2024 оны 04 дүгээр сарын 13-14-ний өдрүүдэд “Хурд спорт авиралт”-ын зааланд зохион байгуулсугай.

2. Улаанбаатар хотын аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 2,440,000 (хоёр сая дөрвөн зуун дөчин мянган) төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын Биеийн тамир, уралдаан тэмцээний зардлаас гаргахыг Нягтлан бодогч (П.Ариунцэцэг)-д зөвшөөрсүгэй.

3. Тэмцээний удирдамжийг батлуулж, мэргэжлийн холбоотой хамтран урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг Спорт, нийтийн биеийн тамирын хэлтэс (С.Саранцэцэг)-т үүрэг болгосугай.

ДАРГА  Ж.ГАНБОЛД

9024010070 СТС4689 9077448

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн 117 дугаар тушаалын хавсралт



Улаанбаатар хотын аварга шалгаруулах спорт авиралтын тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсөв

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт дүн /төгрөг/
1.	Шүүгчдийн зардал	10 x 1 өдөр	60,000	600,000
2.	Үзель, тайз, чимэглэлийн зардал	-	-	1,000,000
3.	Медаль	42 ш	20,000	840,000
НИЙТ ДҮН				2,440,000